

# НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

2013 ОНЫ 05 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2013.05.24.

Улаанбаатар хот

## Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

### 1.1. Зохион байгуулсан ажлын талаар :

Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвөлгөөн 5 дугаар сард 2 удаа зохион байгуулагдсан. Нийслэл, дүүргийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж, [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) сайтад байршуулан ажилласан.

“Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал” сэдэвт сургалтыг хороодын 120 албан хаагчдад зохион байгуулж, хороо бүрт Эрүүл мэндийн индекс тооцох 68 үзүүлэлтийн дагуу судалгааны ажил хийгдэхээр бэлтгэж байна.

### 1.2. Иргэдийн өргөдөл, санал хүсэлтийн талаар:

Улаанбаатар сонсож байна “Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх үйл ажиллагааг удирдлагын заалтын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2013 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар нийт 791 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт 791 өргөдлөөс шийдвэрлэсэн 664 буюу 84%, шийдвэрлэх шатандаа 126 буюу 16%, хугацаа хэтэрсэн 1 өргөдөл, гомдол байна.

Долоо хоног бүрийн 3 дахь өдөр Засаг даргын иргэд хүлээн авах уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. 2013 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар Засаг дарга нийт 318 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.

“Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем” –ээр ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

№	Ангилал	Нийт	
		Тоо	Хувь
1	Call center	177	25%
2	Ub.1200.mn	12	2%
3	11 – 11 төв	127	18%
4	Иргэдийг хүлээн авах төв	18	3%
5	Байгууллага	377	53%
6	<b>Нийт</b>	<b>711</b>	<b>100%</b>

Төрийн дээд шагналаар шагнуулахаар ирүүлсэн 23 иргэний материалын бүрдлийг хангуулан хүлээн авч дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар дэмжигдэн, НЗДТГазарт 01/1016 тоотор хүргүүлсэн.

### **1.3. Тайлан мэдээ, хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн талаар:**

5 дугаар сарын байдлаар Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт нийт 238 албан бичиг ирсэн байна. Засаг даргын захирамж 66, Тамгын газрын даргын тушаал 64, албан бичиг 210-ыг тус тус бэлтгэн боловсруулсан байна.

### **1.4. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар:**

5 дугаар сард 17 иргэнд хууль зүйн зөвөлгөө өгч ажилласан.

### **1.5. Хэвлэл, мэдээллийн чиглэлээр:**

Нийгмийн хөгжлийн хэлтэсээс “Гэр бүлийн үнэ цэнэ” цуврал арга хэмжээ зохион байгуулж, тус бүрт нь мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн болно. Мөн Гэр бүл баяжуулалтын цуврал сургалтаар ETV телевиз 10 минутын нэвтрүүлэг бэлтгэн цацсан. Мөн Дэлхийн гэр бүлийн өдрөөр Иргэний бүртгэлийн хэлтсээс Азтай гэр бүл, Азтай хүүхдүүд тодруулж хүндэтгэл үзүүлсэн үйл явдлыг олон нийтэд мэдээлсэн.

Тавдугаар сарын турш ЗДТГ, түүний харъяа хэлтсүүдийн хийсэн ажлууд дотроос Гандангийн дэнж дэх нийтийн байрнуудын шалгалтыг эхлүүлсэн нь олон нийт болоод хэвлэл мэдээллийнхний анхаарлыг ихээхэн татлаа. Гэрээтэй хамтран ажилладаг хэвлэлүүдээс гадна Улс төрийн тойм, 25-дугаар суваг телевиз, NBS, Eagle, Эх орон, TV8 телевизээс цуврал сурвалжлага бэлтгэсэн байна.

Мөн Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс хамтран шар усны үерээс сэргийлэн үерийн далангийн лаг шаврыг цэвэрлэсэн ба энэ үеэр мөн 10 минутын нэвтрүүлгийг ZATV, ETV хийсэн ба өдөр тутмын хэвлэлүүд, сайтуудад мэдээ, мэдээллийг нь байршуулсан болно.

Тавдугаар сард Ерөнхийлөгчийн зарлигаар мод тарих өдөр тохиосон, Өрхийн эмнэлгүүд Төсвийн Ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулсан, Хэнтий аймгийн Батширээт сумтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан, “Монгол цэрэг” өдөрлөг болсон зэрэг олон үйл явдал өрнөснийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилжээ.

Дүүргийн [www.bgd.mn](http://www.bgd.mn) вэб сайтанд тогтмол баяжилт хийн ажиллаж байна.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

### **2.1.Төсвийн орлогын талаар:**

2013 оны 5 сарын байдлаар 20-ны байдлаар  $\text{᠒᠔᠑᠑.1᠑᠑.1᠑᠑.1᠑᠑}$  3 тэрбум 495.1 сая  $\text{᠒᠔᠑᠑.1᠑᠑.1᠑᠑.1᠑᠑}$  урьдчилсан байдлаар эхний 5 сарын орлогын төлөвлөгөө биелэх боломжтой байна.

Жил болгон уламжлал ёсоор зохион байгуулдаг татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулж, төсвийн орлогын бааз суурь, татварын бус орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг Татварын хэлтэс болон Баянгол Шинэ-Өргөө ОНӨААТҮГ-ын хамтран зохион байгуулсан.

### **2.2.Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:**

2013 оны эхний 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагад 7 тэрбум 846.8 сая, улсын төсвийн байгууллагад 17 тэрбум 183,7 сая төгрөгийн, бүгд 25 тэрбум 30,5 сая төгрөгний зарлагын санхүүжилт хийсэн. Төлбөр тооцооны мэргэжилтнүүд, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нартай хамтран 2013 оны эхний 5 сарын олгогдсон

санхүүжилтийн хүрэлцээ, төсвийн тооцоо хийж, өр авлага гарах эсэх талаар судлан ажиллаж байна.

### **2.3. Мэдээ, тайлангийн талаар:**

Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтарч Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 21 өрхийн эмнэлэг, 7 төр захиргааны байгууллага, 18 сургууль, 30 цэцэрлэг өмч эзэмшлийн гэрээг 100 хувь байгуулж нийт 76 байгууллагын өмч хөрөнгийн нэгтгэл хийж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.

Дүүргийн Засаг даргын А/219 тоот захирамжийн дагуу дүүргийн нийтийн зориулалттай өмчийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэж байна.

Нийт 130 төсөвт байгууллагын эхний 4 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч нэгтгэж, нийслэлийн төрийн санд хуулийн хугацаанд хүргүүлээ.

### **2.4. Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн талаар:**

2013 оны төсвийн тодотголд оруулах хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

2014 оны хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын тооцоо судалгааг гаргаж байна.

БГД-ийн хэмжээнд дээврийн засвар хийх шаардлагатай 75 байрнаас өргөдөл гомдол бичгээр ирсэн бөгөөд уг гомдлуудын дагуу ажлын хэсэг гаран ажиллаж газар дээр нь очиж шалган зураг авч баримтжуулсан бөгөөд зайлшгүй засвар хийх шаардлагатай дээврийн засварын ажлын хөрөнгө оруулалтыг төсвийн тодотголд оруулахаар Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон СӨХ-ийн дээд зөвлөл рүү жагсаалтыг гарган хүргүүлсэн.

Хаан Банкнаас жил бүр зохион байгууллагдаг оюутны тэтгэлэгт хөтөлбөрт БГД-ийг төлөөлөн тус хэлтсээс мэргэжилтэн оролцсон бөгөөд нийт 23 төгсөх ангийн сурагчдын материал ирүүлснээс 5 хүүхдийн материалыг эцсийн шатанд шалгаруулав.

### **2.5. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах талаар:**

Дүүргийн 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ машин техник хэрэгсэл авах, Замын цагдаагийн тасагт машин техник хэрэгсэл авах ажил тус тус тендер зарлагдсан. Дохиоллын систем тавих ажлын гэрээ байгуулагдан ажил хүлээлцэж байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Нийслэлийн 2013 оны төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 350,0 сая төгрөгийн 2 ажил төлөвлөх шатандаа явж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих тохижуулалт, гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн болон орон сууцны гадна талбайг камержуулах, хаалгыг электрон түгжээтэй хаалгаар солих нийт 2,800,0 сая төгрөгийн 3 ажил ажлын хэсэг гаран судалгааны шатандаа, хогийн цэг байгуулах ажил 200,0 төгрөгийн ажил үнэлгээний хороо байгуулагдан ажлаа төлөвлөх шатандаа тус тус явагдаж байна.

### **2.6. Бусад ажлын талаар:**

Орон нутгийн төсөвт тодотгол оруулах асуудлыг ИТХ-н хуралдаанаар батлуулсан. Төсвийн тодотголоор орон нутгийн орлогыг 2 тэрбум 50.0 сая төгрөгөөр, зарлагыг 3 тэрбум 546.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Дүүргийн 2012 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг 2013 оны 4 дугаар сарын 24-ний өдрийн ИТХурлын Төлөөлөгчидийн хуралдаанд өргөн барьж хэлэлцүүлэн, батлуулсан.

Төсвийн тухай хуулийн 40.1-д заасны дагуу дүүргийн төсвөөс санхүүждэг төрийн болон төрийн бус өмчийн 130 байгууллагын төсвийн шууд захирагчтай Дүүргийн засаг дарга 2013 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

Дүүргийн хэмжээнд 2012 оны жилийн эцсийн 14706 ААН байгууллагын тайланг хүлээн авахаас 11006 ААН байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэлийг 3 сарын 4-нд Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн .

Аæ äðóéí íýæ, áàéãðóéëääðóáúí 2013 ïü 1 дүгээр улирлын санхүүгийн ðàééàíг ðàðèì ñçëæýúäýüð хүлээн äâ+ тулган ääðàéãääæуулж байна. Өнөөдрийн байдлаар 13000 орчим аж ахуйн нэгж, байгууллагын ðàééàíг хүлээн авч баталгаажуулаад байна.

Дүүргийн Засаг даргын А/239 тоот захирамжийн дагуу Татварын хэлтсийн орон тооны бус байцаагч нартай 2013 оны хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

## **Гурав. Дэд бүтэц, тохижилтийн хүрээнд**

### **3.1. Байгаль орчин, агаарын бохирдлыг бууруулах ажлын талаар:**

Баянгол дүүрэг нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд багтаж иргэдэд боловсруулсан түлшийг хөнгөлөлттэй үнээр түгээх ажлыг 2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2013 оны 1-р сард Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг даргын “Агаарын чанарыг сайжруулах бүс шинэчлэн тогтоох тухай” 2013 оны А-13/А-30 дугаар хамтарсан тушаал, захирамж батлагдан гарч дүүргийн гэр хорооллын 9 хорооны айл өрхүүдийг боловсруулсан түлш болон бүрэн шаталттай, сайжруулсан зуух нэвтрүүлэх хосолмол бүсэд хамруулсан.

Агаарын чанарыг сайжруулах хосолмол бүсэд “Роял Өүшн” ХХК-ийн гэрийн болон ханан пийшингийн “Дөл” зуух, “Хүрд” ХК-ийн нам даралтын усан халаалтын зуухнууд нийлүүлэгдэж байгаагаас 2013.05.20-ны өдрийн байдлаар нийт 5687 өрхөд зуухыг хөнгөлөлттэй үнээр борлуулаад байна.

Баянгол дүүргийн гэр хорооллын 9 хороонд нийт 12461 өрхөд боловсруулсан түлш түгээх цэгүүдээр дамжуулан 2013 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар үртсэн шахмал түлш 3783.3 тн, хагас кокосжуулсан түлш 4073.6 тн нийт 7857.9 тн түлш хүлээж авч борлуулаад байгаа ба дүүргийн салбар хороо нь 7 хоног бүр борлуулалтын цэгт ажиллаж боловсруулсан түлшний захиалга, мэдээ тайлан, тооцоог нэгтгэн иргэдэд хүртээмжтэй хүрч байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж, борлуулагчидтай хийсэн гэрээний дагуу түлш борлуулсаны орлогыг дансанд төвлөрүүлж 449.668.000 төгрөгийг “Цэвэр агаарын сан”-д тушаагаад байна.

### **3.2. Орчны бохирдол, хог цэвэрлэгээний талаар:**

Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Дүүргийн хэмжээнд иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын А/86 дугаар захирамж гарч нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайд үүссэн хог хаягдал, цас мөс, хальтиргаа гулгаа, нийтийн өмчийн эд хөрөнгийг тогтмол цэвэрлэх нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүрийн Бямба гаригт 11.00-14.00 цагийн хооронд тогтмол хийж байхаар шийдвэрлэгдэж 5-р сард 4 удаагийн их цэвэрлэгээ зохион байгуулаад байна.

Дүүргийн Засаг даргын 2013 оны А/23 тоот захирамжийн дагуу 9 хорооны нийт 6,9 км урттай, 924м<sup>3</sup> үерийн хамгаалалтын далан сувгийн цэвэрлэгээг Онцгой байдлын хэлтэс болон Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран 50 иргэн ажиллуулж, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг 05-р сарын 04-өөс 05-р сарын 11 хүртлэх хугацаанд зохион байгуулж, нийт 980 тонн лаг шавар цэвэрлэсэн.

### **3.3. Тохижилт, ногоон байгууламжийн ажлын талаар:**

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн сав байрлуулах ажлын хүрээнд Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран дүүргийн Энхтайвны өргөн чөлөө, Амарсанаа, Чингүнжав, Энэбишийн өргөн чөлөөнүүдэд нийт 3 компани 115 ширхэг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг суурилуулсан. Мөн нийтийн эзэмшлийн 5 гудамжинд 25 ширхэг сандлыг “Хэтийн зам” ХХК хийж суурилуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дүүргийн Засаг Даргын 2013 оны А/216 дугаар захирамжийн дагуу 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Дүүргийн хэмжээнд бүх нийтээр мод тарих ажил зохион байгуулагдлаа. Мод тарих өдрийн Нийслэлийн хэмжээний нээлт 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатарын талбайд болж “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвхийг дээшлүүлж, амьжиргааг дэмжих төв” ТББ, “Ногоон байгууламжийг бий болгох, мэргэжлийн байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүдийг дэмжих сан”, Монголын ногоон эмэгтэйчүүдийн холбооны сургалт үйлдвэрлэлийн төв, “Од-Тоб” ХХК, “Ургамлын далай” ХХК-ууд оролцож ногоон байгууламжийн чиглэлээр үзэсгэлэн худалдаа гаргаж ажиллалаа.

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн дүүргийн нээлтийн ажиллагаа 05 дугаар сарын 11-ний өдөр Өргөө кинотеатрын өмнөх талбайд зохион байгуулагдлаа. Нээлтийн ажиллагаанд ЗДТГ, хороо, харьяа хэлтэс албадын албан хаагчид оролцож дүүргийн хэмжээнд нийт 6575ш мод , бут сөөг таригдсан.

### **3.4. Гэрэлтүүлгийн ажлын талаар:**

Гэрэлтүүлгийн өдөр тутмын асалтын хэвийн ажиллагааг хангуулахаар “Цахилгаан тээвэр” компанийн инженер техникийн ажилчидтай хамтарч нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн Энхтайваны өргөн чөлөө, Ард аюуш, Энэбишийн өргөн чөлөө, Амарсанаа, Чингүнжав, Замчид, Нарны зам, Шүүх, Дилав хутагт Жамсранжав, Жалханз хутагт Дамдинбазар зэрэг гудамжнуудад тэжээлийн кабель, группийн кабель, гэрлийн шон, ламп, гал хамгаалагч гэх мэт гэмтлийг тухайн бүр нь засварлуулж хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Магсаржав, Ард Аюуш, Энэбиш, 10,11-р хороо, Занабазар, Нарны замын тэжээлийн кабельд их засвар хийлгэхээр 2012 онд 146 сая төгрөгийн төсөвт тусгагдаж батлагдсан бөгөөд 2013 онд барилгын ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд Магсаржав, Ард Аюушийн гудамжны тэжээлийн кабель шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан.

Орон сууц, гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан 1 тэрбум төгрөгийн зураг төсвийн задаргаа болон байршил, тооцоо судалгааг гаргаж бэлэн болов.

Ардчилсан орнуудын хамтын ажиллагааны уулзалтыг угтан Нийслэлийн авто замын газраас зохион байгуулсан замын нөхөөсийн ажилд Занабазар гудамжинд 174,79м Квт замын хагаралд засвар үйлчилгээ хийлгэсэн.

Нийслэлийн төсөвт 2014 онд гэрэлтүүлгийн барилгын ажил хийлгэхээр зураг төсвийг бэлтгэхэд зориулан 200 сая төгрөг батлагдсан тус зардалд тусгуулахаар 2014 онд хийх шаардлагатай гэрэлтүүлгийн байршил, цахилгаан хангамж, зэргийн судалгаа тооцоо гаргаж байна.

“Цахилгаан тээвэр” ОНӨААТҮГ-ын 2013 оны 03-р сарын 20-ноос 04-р сарын 20-ны хоорондох гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан.

Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг эрчим хүчээр хангуулах гэрээ боловсруулж “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨК, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд хүргүүлж баталгаажуулав.

Гэрэлтүүлгийн шалгалт 3 удаа хийхэд дүүргийн гэрлийн асалт 91,2% дундажтай байна.

### **3.5. Гадна зар сурталчилгааны байгууламжийн ажлын талаар:**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд “Гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын хэрэгжилтын ажлын явцын танилцуулга бэлтгэж хүргүүлэв.

Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Хасбаатарын гудамжны авто зам шинэчлэлийн ажлыг “Хансуун Зам” ХХК байгууллага гүйцэтгэж хийгдэж байна. Тус байгууллагаас 11 хорооны “Жаст” бензин түгээгүүрийн баруун урд буланд байрлах “Голомт” банкны 4\*9 хэмжээтэй 1 ширхэг самбар буулгаж авах тухай албан бичиг ирүүлсэний дагуу дүүрэгтэй гэрээ байгуулан Ажиллаж байгаа “Дунд уртын Кран” ХХК-аар буулгуулж талбайг чөлөөлөв.

### **3.6. Автозам төлөвлөлт ашиглалт үйлчилгээ:**

Нийслэлийн Авто замын сангийн хөрөнгө оруулалтын саналд дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны хороолол дунд 16 хорооны 60 байршилд 12 км авто замын засвар үйлчилгээ хийлгэхээр судалгаа гаргаж үүнээс 6 хорооны 8 байршилд 4.1 км замын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдэхээр болсон.

Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Баруун дөрвөн замын өргөтгөл шинэчлэл, Саппоро тойргийн өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийгдэхээр батлагдаж Баруун дөрвөн замын тендерийн барилгын гүйцэтгэгчээр БНХАУ-ын ЗГ-ын Экспортын хөнгөлттэй зээлээр “China railway international limited” кампони шалгарсан. Саппоро тойргийн ажлын гүйцэтгэгч шалгараагүй байна.

2014 оны Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэхээр 9 хорооны нутаг дэвсгэрийн 14 байршилд 6,1 км авто замын өргөтгөл шинэчлэлийн зураг төвсийн санал хүргүүлсэн.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн СӨХ-ны үйл ажиллагаа, хог хаягдал, рекламны байгууламж, орон сууцны хорооллын дээвэр болон лифтний засвар, гэрэлтүүлэг, зам талбайн засвар зэрэг 43 иргэний гомдол, санал, 40 албан бичгийг хүлээн авч асуудлыг шийдвэрлэсэн.

## Дөрөв. Худалдаа, ахуй үйлчилгээний чиглэлээр

### 4.1. Зохион байгуулсан ажил:

- БГД-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 49 дэлгүүрт 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн “Нөөцийн мах” худалдаж эхэллээ. Энэ сарын 16-ны өдрийн байдлаар 419.6 тн нөөцийн махыг татан авч худалдаанд гаргасан байна.
- Нийслэлийн Аудитын газраас ирсэн албан тоотын дагуу нөөцийн мах худалдаалалтын талаар санал асуулгыг 120ш хувилж ШЗБХТөвийн “Ганзам”, “Наран март” ХХК, “Дүүхээ” ХХК, “Гурван мөнх хаан” ХХК–ны дэлгүүрүүдээс санал асуулга авлаа.
- “Тамхины хяналтын тухай”, “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиудын эмхтгэлийн эх хувийг бэлтгэж Хууль зүйн үндэсний хүрээлэнд хэвлүүлэхэд бэлэн боллоо.
- 16-р хороонд шатсан 5 айлд хүнсний тусламж үзүүлэхээр 5 худалдааны төвийн эздүүдтэй уулзаж 5 шуудай гурил, 5 уут цагаан будаа, 5 уут элсэн чихэр, 5 кг бүхий 5 ургамлын тос зэрэг хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн тусламж олгов.
- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүнсний ногооны үр авах хүсэлтээ гаргасан 6 байгууллага аж ахуйн нэгж, 172 өрхийн судалгааг хороодоос нэгтгэн нийслэлийн ҮХААГ-г хүргүүлж, хүрэн манжин 1,5кг, урт сонгино 4кг, шар лууван 4кг, байцаа 1кг, бөөрөнхий сонгино 200гр, шар манжин 500гр, лооль 100гр нийт 113,3 кг хүнсний ногооны үр авч 23 хороо 1 хоршоонд хуваарилан өгөв.
- Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ 74ш олгож, аж ахуйн нэгж байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

### 4.2. Хяналт шалгалт:

- Баянгол дүүргийн Засаг дарын 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/230 тоот “Эрүүл ахуйн шаардлага, тогтоосон хэм хэмжээг зөрчин зөвшөөрөлгүй зарж байгаа хүнсний бүтээгдэхүүний худалдааг зогсоож арга хэмжээ авах тухай” захирамжаар 13, 14, 15 дугаар хорооны ил задгай худалдаа гар дээрх худалдаа /ил задгай худалдаа, шорлог гэх мэт/ эрхлэгч нарт дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран хяналт тавин ажиллаж шорлогны мах, тэрэг 4ш, тоног төхөөрөмж 12ш зэргийг хураан авсан.
- 1200, 1111 дугаарын утсанд болон бичгээр ирүүлсэн 10 өргөдөл, гомдлын хариуг Мэргэжлийн хяналтын хэлтэс, цагдаагийн хэлтэстэй хамтран шалгаж арга хэмжээ авсан тухай гомдол гаргасан иргэдэд мэдээллээ.
- ЗАА-ны ХҮҮХ, СХЗГазрын БТБХ-ын дарга нарын баталсан удирдамжийн дагуу ХҮҮХ-ын мэргэжилтэн Д.Ганбаа, СХЗГ-ын мэргэжилтэн Б.Гэрэл, Б.Баярцэцэг нарын хамт дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийтийн халуун усны газруудад аттестатчилал 2013 оны 04 сарын 30-наас 05 сарын 02-ны өдрүүдэд явууллаа. Аттестатчилалд нийт 14 халуун ус бүртгэлтэйгээс 1 халуун усны газар үйл ажиллагаагаа өөрчилсөн, 2 халуун усны газар ажиллаагүй, 11 халуун ус хамрагдлаа. Эдгээр халуун усны 5 нь аж ахуйн нэгж, 6 нь хувь иргэн ажиллуулж байгаагаас “Эж эрдэнэ” ХХК, “Онги тур” ХХК-ны 2 халуун усны газар аттестатчилалд тэнцэж, 9 халуун усны газар тэнцээгүй дүнтэй гарлаа.
- СХЗГазар, Боловсролын хэлтэс, ХҮҮХ хамтран удирдамжийн дагуу ЕБС, цэцэрлэгүүдэд 2013 оны 05 сарын 6-9-ний өдрүүдэд хэсэгчилсэн хяналт, шалгалт хийж 18 газар хамрагдаж дундаж үнэлгээ 84,9 хувьтай хангалттай үнэлгээ авлаа.
- Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхэлж буй иргэдийг бүртгэх тооллого явуулах Дүүргийн Засаг даргын 2013.05.09-ний А/225 тоот захирамж боловсруулан 1, 2-р хороогоор тооллого явуулж эхлээд байна.

### **4.3. Сургалт, семинар:**

- Дүүргийн Засаг даргын А/255 Захирамжаар 5 сарын 16-нд “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах технологи” сургалтыг Нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн 38 иргэнд зохион байгуулж иргэдэд хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, ил ба далд хөрсний хог ургамал, өвчин хортонтой тэмцэх арга, ил ба далд хөрсний аж ахуйд төсөл боловсруулах аргачилалыг зааж, зөвлөгөө өгч технологийн хүснэгт болон хүнсний ногооны үрийг тараан өгсөн.
- Нийслэлийн аялал жуулчлалын газраас зохион байгуулсан Манлайлал сэдэвт сургалтанд 12 аж ахуйн нэгжийн удирдлагуудыг оролцуулав.
- Аялал жуулчлалын газар, зочид буудлын холбоотой хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх “Мондевеломент” ХХК-ны “Цагаан өргөө” зочид буудалд зочид буудал, дэн буудлын эрхлэгч нарт “Үзүүлэх сургалт”-ыг зохион байгуулахад 84 хүн оролцов.
- ЕБС-ын тогооч нарт тогоочийн мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулахад 15 хүн оролцож мэргэжлийн үнэмлэх олгох боллоо.

### **Тав. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

#### **5.1 Халамж, тусламж үйлчилгээний чиглэлээр:**

2013 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 16 дугаар хорооны таван айл өрх гал түймэрт шатаж гамшигт өртсөн. Эдгээр таван айлд ЗДТГ, НХҮХ-тэй хамтран Хараагүйчүүдийн үндэсний төвийн ажилчид үйлдвэрлэдэг гэрийн үйлдвэрээс гэр авч тусламж олголоо. Мөн ХҮҮХ-тэй хамтран нэг сарын хүнсний бүтээгдэхүүнээр хангаж буцалтгүй тусламж болох айл бүрд 100 000 төгрөгийн тэтгэмж олголоо.

#### **5.2 Биеийн тамир, спорт, соёлын чиглэлээр:**

2013 оны 05 дугаар сарын 10-12-ны хооронд харьяа хэлтэс албадын дунд зохион байгуулагдсан спортын 4 төрөлт тэмцээнд 15 байгууллагын 300 гаруй албан хаагчид оролцлоо. Байгууллагын нэгдсэн дүнгээр нэгдүгээр байранд 32 оноогоор БТСХороо, хоёрдугаар байранд 28 оноогоор Цагдаа, гуравдугаар байранд 28 оноогоор Онцгой байдлын хэлтсүүд тус тус орлоо.

#### **5.3 Гэр бүлийн үнэ цэнэ сарын аяны хүрээнд хийгдсэн ажлууд:**

2013 оны 05 дугаар сарын 01-нээс 07-ныг дуустал “Гэр бүлийн үнэ цэнэ” сарын аян амжилттайгаар зохион байгууллаа. Тус сарын аянд давхардсан тоогоор 156 өрх гэр бүл гишүүний хамт оролцлоо.

2013 оны 05 дугаар сарын 01-нээс 07-ны өдрийн хооронд “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвийн дор “Гэр бүлийн баяжуулалтын хөтөлбөр” сургалтыг дүүргийн хороодын 4 бүсэд амжилттайгаар зохион байгуулж 125 өрх гишүүний хамт оролцсон.

2013 оны 05 дугаар сарын 13-нд “Гэр бүлийн үнэ цэнэ” илтгэлийн уралдааныг ард иргэдийн дунд нээлттэйгээр зохион байгуулж 95 гаруй иргэд хамрагдаж, 20 иргэний илтгэл тавигдсан.



#### **5.4 “Залуучуудын хөгжил шинэчлэл бодлого, зорилт” чуулган:**

2013 оны 05 дугаар сарын 19-нд Баянгол дүүргийн “Залуучуудын хөгжил, шинэчлэл бодлого, зорилт” анхдугаар чуулганыг зохион байгуулснаас, уг арга хэмжээнд 300 гаруй залуучууд оролцов.

#### **Зургаа. Цэрэг, иргэний хамгаалалтын талаар**

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны мн/50 дугаар тогтоол, Зэвсэгт Хүчний Жанжин штабын даргын 2013 оны н/35 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/347, дүүргийн Засаг даргын 2013 оны А/168 дугаар захирамжуудын дагуу 2013 оны I ээлжийн цэрэг халалт, татлагын ажлыг тогтоосон хугацаанд явуулж дуусгалаа.

#### **6.1. Бэлтгэл ажлын талаар:**

Цэрэг халалт, татлагыг зохион байгуулах дүүргийн Засаг даргын захирамжаар цэрэг татлагын байрыг “Оюуны Ундраа” цогцолбор сургууль дээр зохион байгуулахаар шинэчлэн томилгоожуулсан. Цэрэг татлагын байранд ажиллах бүрэлдэхүүнийг 8 тасгаар зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын дарга, Өэрэг татлагын товчооны даргын 2013 йн А/53 аргаар тушаалаар 92 хүнийг томилон ажиллууллаа.

2012 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар цэргийн ажилтан албанд татагдан 2013 оны 05 сарын 01, 02-ны өдрүүдэд халагдаж ирсэн цэргүүдийг хүлээн авч ажлын байр танилцуулах, сургалтанд бүртгэх арга хэмжээг зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.

Дүүргийн Засаг даргын захирамжийн хавсралтаар цэрэгт татагдагчдын нэрсийн жагсаалтыг хороо тус бүрээр гарган 4 дүгээр маягыг тодотгон, нийт 3100 иргэнд цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас бичсэнээс 2969 иргэн буюу 95,7 хувь нь зарлан дуудах хуудсыг биечлэн хүлээн авч, 2013 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын байранд ирүүлэхээр бэлтгэсэн.

#### **6.2. Цэрэг халалт, татлагын явцын талаар:**

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2013 оны 05 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Ерөнхий зориулалт, Хил хамгаалах газар, Дотоодын цэргийн ангиудаас халагдаж ирсэн дайчдыг хүлээн авах ажлыг Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд зохион байгууллаа.

Цэргийн албанаас халагдаж ирсэн дайчдыг хүлээн авах арга хэмжээнд дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, хүнсний чиглэлээр “ЕЕСС” ХХК, уул уурхайн чиглэлээр “Энх тун газрын хишиг” ХХК, барилга угсралтын чиглэлээр “Гранд лакшари” ХХК, Хувийн хөдөлмөрийн бирж зэрэг байгууллагууд оролцлоо.

Арга хэмжээний үеэр халагдаж ирсэн цэргүүдээс Хөдөлмөрийн хэлтэс 15 иргэнийг ажил идэвхтэй хайгчаар ажлын байранд бүртгэж, 2 иргэнийг сургалтанд хамруулахаар бүртгэж авлаа.

Ирц бүртгэлийн байдалд хяналт тавиулах зориулалтаар “Хөдөлгөөнт хяналтын бүлэг”-ийг 23 хороог 4 бүс болгон хороодын дунд товчооны гишүүдийг томилгоожуулан ажиллууллаа.

Цэрэг татлагын байранд ирж асуудлаа шиедвэрлүүлэх эрүүл мэндийн үзлэгээр 1᠔᠖᠗ иргэнээс 2768 иргэнийг оруулж, цэргийн жинхэнэ албанд татаж Нийслэлийн Засаг даргаас өгсөн тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.

Зарлан дуудах авсан иргэдээс их дээд сургууль, коллежийн оюутан 2035, хуульд заасан ар гэрийн гачигдлаар чөлөөлөгдсөн 67, өвчнөөр 533 иргэн тус тус чөлөөлөгдөж, 201 иргэн зарлан дуудах хуудас аваад ирээгүй байна.

Гэрээт цэргийн албанд элсэхээр сонгон шалгаруулалтанд тэнцсэн 3 иргэнийг судлан 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид хүлээлгэн өгсөн.

Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудад Нийслэлийн Засаг даргын захирамжаар явагдаж байгаа жагсаалч анги, байгууллага шалгаруулах “Монгол цэргийн жавхаа” уралдааны комиссын бүрэлдэхүүнд Цэргийн штабын дарга, хурандаа Л.Ганбаатар 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал ажилласан.

2013 оны 05 дугаар сарын 11-нд дайчилгааны офицер д/х С.Бүдрагчаа цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдыг ахлан Нийслэлийн ногоон бүс Шадивлангийн зусланд хог цэвэрлүүлсэн.

Дүүргийн Ерөнхий боловсролын 10 сургуулийн сурагчдад Зэвсэгт хүчний 013 дугаар анги, 5 сургуулийн сурагчдад ЗХЖШ-ын үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн ангиас “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдэвт цуврал лекц уншиж, энхийн үйлсийг харуулсан баримтат киног үзүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2013 оны А/257 дугаар захирамжаар “Түмэнд ойрхон төрийн үйлчилгээ” аян эхэлж, Цэргийн штабаас удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, 2013 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хуваарийн дагуу 13 дугаар хороонд төлөвлөлт, сургалтын офицер д/х Б.Энхбаатар, мэдээллийн аюулгүй байдлын офицер д/ч Н.Цэцэгбал нар ажиллаж, тус хорооны цэрэг татлагаас хоцорсон 3 иргэний асуудлыг шийдвэрлэж, 1 иргэний санал, хүсэлтийг хүлээн авсан.

2013 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас аваад хугацаандаа ирээгүй 201 иргэнийг мэдэгдэх хуудсаар дуудаж асуудлыг шийдвэрлэж эхлээд байна.

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.НЯМЦЭЦЭГ

МЭДЭЭ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭРДЭНЭГАВАА